



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 4/522

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.3.4 дэх заалт, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэлийн 4 дүгээр бүлгийн 4.1.1 дэх зорилт, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.1 дэх зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Газар тариалан, жимс жимсгэнэ" төсөл арга хэмжээний хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас гэрээгээр нийлүүлэгдэж буй хөдөө аж ахуйн зориулалттай трактор, техник тоног төхөөрөмжийн иж бүрдлийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Д.Батбилэг -(аймгийн Засаг даргын зөвлөх)

Гишүүд: Б.Гайтав -(Хүнс, хөдөө аж ахуйн газрын газар тариалангийн үйлдвэрлэл, технологи хариуцсан мэргэжилтэн)

Т.Галсан -(Хүнс, хөдөө аж ахуйн газрын нягтлан бодогч)

Р.Пүрэвдорж-(Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:Т.Сүхбаатар -(Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2.Хөдөө аж ахуйн зориулалттай трактор, техник тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлыг шуурхай зохион байгуулан, дүнг танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ

